



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А182

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанийн шинэ хэсгийн тэжээлийн усны шугамын булан, хаалт солих. /Тэжээлийн усны блок хаалт ду150 ру100 солих/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Г.Болдсайхан /Хангамж, үйлчилгээ хариуцсан дэд захирал/
Нарийн бичгийн дарга:	М.Энхбат /Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн/
Гишүүд:	Д.Пүрэвдорж /Зуухан цехийн дарга/ Э.Мөндөр /Монголын эрчим хүчний барилга угсралт, засварчдын холбооны эксперт/ Д.Тарваа /Аудитын боловсрол төв төрийн бус байгууллагын гишүүн/

2. Холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу тендерийн бичиг баримтыг бүрдүүлэн тендерийн ажиллагааг явуулж үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Болдсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэх, Үнэлгээний хорооны гишүүдийн мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч компанийн эрх бүхий албан тушаалтанд хугацаанд нь бүртгүүлэхийг нарийн бичгийн дарга /М.Энхбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.БЯМБААХҮҮ

Tushaal.A4.2019

389990521

